

БАТЛАВ:  
ШУТИС-ийн ХАРЪЯА ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ



Т.ТӨРМӨНХ

БАТЛАВ: “ПИ ПИ ПИ ЭМ ЖИ ЭЛ”  
ХХК-ний ЗАХИРАЛ



Б.БАЯРБАТ

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20 19 он... 06 сар... 04 өдөр

№ 19/10

Улаанбаатар хот

“Пи Пи Пи Эм Жи Эл” ХХК

Нэг талаас “.....” -ыг төлөөлж Х.Баярмал  
(цаашид Захиалагч гэх), нөгөө талаас Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн харьяа Хөнгөн Үйлдвэрийн Судалгаа Хөгжлийн Хүрээлэнгийн Итгэмжлэгдсэн лабораторийг төлөөлж Лабораторийн эрхлэгч С.Саранцэцэг (цаашид Гүйцэтгэгч гэх) нар харилцан тохиролцож дор дурьдсан нөхцөлтэйгээр гэрээг байгуулав.

#### Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээний зорилго нь малын гаралтай ширхэгт болон аливаа нэхмэлийн материалын чанарын болон тоон шинжилгээ, ээрмэл болон нэхмэл бүтээгдэхүүний геометрийн болон химийн шинжилгээ, тэдгээрийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, маргаан таслах, судалгаа мэдээллийн сан үүсгэхэд үр өгөөжтэй хамтран ажиллахад оршино.

- 1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтийн дагуу үйлчилгээ явуулна. Тухайн үйлчилгээг гэрээний салшгүй хэсэг болох техникийн асуудал буюу гүйцэтгэх шинжилгээний үзүүлэлтүүдийг дээж хүлээн авах бүртгэлд бүртгэн хөтлөнө.
- 1.2. Захиалагч нь үйлчилгээний төлбөрийг төлөх үүргийг хүлээнэ. Судалгаа шинжилгээний төлбөрийг хавсралтанд заасан тарифаар бодож тооцно. Хавсралт.1
- 1.3. Талуудын түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ баталгаажиж, үйлчилгээний эрх үүснэ.
- 1.4. Гэрээг хоёр хувь үйлдэж талууд үйл ажиллагааны үндсэн баримт бичиг болгоно.

#### Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

- Гүйцэтгэгч нь гэрээнд зааснаар Захиалагчийн шаардлагын дагуу тохиролцсон хугацаандаа чанартай үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээнэ.

- Гүйцэтгэгч нь захиалагчаас ирүүлсэн сорьцыг сорилтын шинжилгээнд хэрэглэгдэх хэмжээний дагуу шаардах эрхтэй.
- Гүйцэтгэгч нь Захиалагчид ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээллийг зохих ёсоор хангана
- Гүйцэтгэгч нь үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө захиалагчаас нэхэмжлэх эрхтэй.
- Гүйцэтгэгч нь шинжилгээний үр дүнг Хөнгөн Үйлдвэрлэлийн Судалгаа Хөгжлийн Хүрээлэнгийн Лабораторийн албан ёсны тамга тэмдэгтэй бланкан дээр баталгаажуулан гаргаж өгөх үүрэгтэй.

## 2.2 Захиалагчийн эрх, үүрэг:

- Захиалагч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд оролцохгүйгээр үйлчилгээний явцад хяналт тавих эрхтэй.
- Захиалагч нь гэрээнд заасан дагуу үйлчилгээний хэмжээ, хугацааг зөвшилцөх эрхтэй.
- Захиалагч нь захиалсан ажлын төлбөрөө тохиролцсон хугацаандаа төлөх үүрэгтэй.
- Захиалагч нь гэрээг цуцлах бол 1 сарын өмнө Гүйцэтгэгчид бичгээр урьдчилан мэдэгдэж цуцлах эрхтэй.

2.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## Гурав. Гэрээний хугацаа

3.1 Энэхүү гэрээ нь 20<sup>19</sup> оны <sup>06</sup> дугаар сарын <sup>04</sup> -с эхлэн <sup>60</sup> сарын хугацаанд хүчинтэй байна.

3.3 Энэхүү гэрээг хоёр талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр баримтжуулан сунгаж болно.

## Дөрөв. Төлбөр төлөх нөхцөл

4.1 Гэрээний заасан үйлчилгээний төлбөрийг Гүйцэтгэгчийн нэхэмжилсний дагуу төлж барагдуулсан байх ба сорилтын шинжилгээний дүнгийн хуудас авахдаа төлбөрийн баримтаа авч ирнэ.

4.3 Төлбөрийг Хөнгөн үйлдвэрийн СХХүр н.с (РД: 5907888) “Төрийн сан”-ийн 100900015472 тоот дансанд тушаана.

## Тав. Гэрээнд өөрчлөлт оруулах тухай

5.1 Энэ гэрээнд талуудын хүсэлтээр, эсвэл Монгол улсын хуулийн дагуу өөрчлөлт оруулж болно.

5.2. Талууд Гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор өөрчлөгдсөн нөхцлийг бичгээр мэдэгдэнэ.

5.3 Талуудын хүсэлтээр гэрээний хугацаа дуусахаас өмнө Гэрээг цуцалж болно. Энэ талаар 1 сарын өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Энэхүү холбогдох бүх маргааныг талууд хоорондоо хэлэлцээр хийж шийдвэрлэнэ.



6.2. Хэлэлцээрийн замаар энэ маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### Долоо. Гэрээний хүчин төгөлдөр нөхцөл

7.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн 5 (таван) жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Гэрээний биелэлтийг жилийн эцэст талууд тус тусын удирдлагад тайлагнаж, дүн шинжилгээг хийнэ.

6.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинжилгээний ажлын хүрээг өргөтгөх, гэрээний хүчин төгөлдөр хугацааг тодотгох, сунгах талаар талууд зөвшилцөж шийдвэрлэнэ.

6.4 Энэхүү гэрээг Улаанбаатар хотноо 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдөр монгол хэл дээр хоёр хувь үйлдэж баталгаажуулав.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ШУТИС-ийн ХАРЪЯА ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН

“ПИ ПИ ПИ ЭМ ЖИ ЭЛ” ХХК-ийг  
ТӨЛӨӨЛЖ:

ХҮРЭЭЛЭНГИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ

*С. Саранцэцэг*

..... С.САРАНЦЭЦЭГ

*Менеджер Х.Балршаа*  
.....  
*Д.Б.Р.У*  
.....

Байршил хаяг :

ШУТИС-ийн харъяа ХҮСХХүрээлэн.  
Монгол улс, Улаанбаатар хот,  
Хан- Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 52,  
ШХ -36/15

*БТӨ чиг дүр хөрөө, 2-р хороолол*  
.....  
*ХД-55-1/1007*  
.....  
*93213355, 70008908*  
.....